



БАВХАН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018. 12 сарын 10 өдөр

дугаар 76

Улаанбаатар

"Баруун бүсийн тамирчдыг олимпд бэлтгэх төв" орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар байгуулах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын "ж", 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Усан бассейн бүхий спорт цогцолбор ашиглалтад орсонтой холбогдуулан "Баруун бүсийн тамирчдыг олимпд бэлтгэх төв" орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар байгуулсугай.

2. "Баруун бүсийн тамирчдыг олимпд бэлтгэх төв" орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийг нэгдүгээр хавсралтаар, удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Үйлдвэрийн газрын даргыг томилж, бүтэц орон тоог баталж, үйл ажиллагааг эхлүүлэх санхүүжилтийн болон удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга /Д.Батсайхан/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.БАЛХЯРВАА